

ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2024 оны ... дугаар
сарын ны өдөр

Дугаар/.....

Улаанбаатар хот

Журам шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 8 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. “Нөхцөл байдлын үнэлгээ хийх журам”-ыг шинэчлэн баталсугай.

2. “Гэр бүлийн эрсдэлийн нөхцөл байдлын үнэлгээний маягт”-ыг нэгдүгээр, “Аюулгүй байдлын нөхцөл байдлын үнэлгээний маягт”-ыг хоёрдугаар, “Гэр бүлийн давуу тал ба хэрэгцээний үнэлгээний маягт”-ыг гуравдугаар, “Гэр бүлд нь эргэн нэгтгэх нөхцөл байдлын үнэлгээний маягт”-ыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

3. Журмын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газар /...../-т, Цагдаагийн ерөнхий газар /...../-т, Боловсролын ерөнхий газар /...../-т, бүх шатны Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4. Энэхүү журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Гэр бүлийн бодлогын газар /...../-т даалгасугай.

5. Энэ журам гарсантай холбогдуулан Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн А/120, А/178 дугаар хамтарсан тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР,
НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН САЙД

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД
ХЭРГИЙН САЙД

.....

.....

НӨХЦӨЛ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ ХИЙХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журам нь хүүхдийн эсрэг хүчирхийллийн улмаас учирсан эсхүл учирч болох гэр бүлийн эрсдэлийн хүчин зүйлсийг үнэлж эрсдэлийн түвшинг тогтоох, хүүхдийн аюулгүй байдлын нөхцөл байдлын үнэлгээний дүнд үндэслэн хүүхдийн аюулгүй байдлыг хангах гэрээ байгуулах, хүүхдийг гэр бүлийн орчинд эсхүл гэр бүлээс тусдаа хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх шийдвэрийг гаргах, гэр бүлийн давуу тал, хэрэгцээг үнэлэх, хүүхэд, гэр бүлд чиглэсэн хамгааллын үйлчилгээний хэрэгцээг тодорхойлох, гэр бүлээсээ тусдаа орчинд хүүхэд хамгааллын үйлчилгээнд хамрагдсан хүүхдийг гэр бүлд нь эргэн нэгтгэх нөхцөл байдлыг үнэлэх зэрэг хүүхэд хамгааллын үйлчилгээний хэрэгцээ, шаардлагыг тодорхойлохтой холбоотой харилцааг зохицуулна.

1.2. Хүүхэд хамгааллын “нөхцөл байдлын үнэлгээ” гэж хүүхдийн эсрэг хүчирхийлэлд хүргэсэн эсхүл хүргэх гэр бүлийн эрсдэлийг үнэлэх, хүүхдийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээ, хүүхэд, түүний гэр бүлийн давуу тал, хэрэгцээг тодорхойлох, хүүхдийг гэрт нь эргэн нэгтгэх нөхцөл, аюулгүй байдлыг үнэлэх зэрэг хүүхдийн эсрэг хүчирхийлэлд өртсөн хүүхдэд тохирох хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай мэдээллийг цуглуулах, дүн шинжилгээ хийх судалгааны аргыг хэлнэ.

1.3. Хүүхэд хамгааллын нөхцөл байдлын үнэлгээг хийхдээ Хүүхэд хамгааллын тухай болон холбогдох бусад хууль тогтоомжийг дагаж мөрдөнө.

1.4. Хүүхэд хамгааллын тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 18 дугаар зүйлд заасны дагуу хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан нөхцөл байдлын үнэлгээг хийхдээ шаардлагатай тохиолдолд хамтарсан баг эсхүл холбогдох мэргэжилтний туслалцааг авна.

1.5. Хүүхдийн эсрэг хүчирхийллийн нөхцөл байдлыг үнэлэх, хүүхэд хамгааллын үйлчилгээний хэрэгцээг тодорхойлох, үйлчилгээг төлөвлөх, хүргэх, үнэлэх, хаахдаа “Нийгмийн ажил үйлчилгээний нийтлэг шаардлага MNS 6949:2021” стандартыг мөрдөж ажиллана.

1.6. Хүүхдийн эсрэг хүчирхийллийн нөхцөл байдлын үнэлгээ нь хуулийн байгууллагад нотлох баримтын хэмжээнд үнэлэгдэнэ.

1.7. Үйлчилгээний кодыг Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн кодын дагуу кодлоно.

Хоёр. Хүүхдийн эсрэг хүчирхийллийн нөхцөл байдлын үнэлгээ хийх

2.1. Хүүхдийн эсрэг хүчирхийллийн нөхцөл байдлын үнэлгээнд дараах дөрвөн төрлийн нөхцөл байдлын үнэлгээ хамаарна. Үүнд:

2.1.1. Гэр бүлийн эрсдэлийн нөхцөл байдлын үнэлгээ,

2.1.2. Аюулгүй байдлын нөхцөл байдлын үнэлгээ

2.1.3. Гэр бүлийн давуу тал, хэрэгцээний нөхцөл байдлын үнэлгээ

2.1.4. Хүүхдийг гэр бүлд нь эргэн нэгтгэх нөхцөл байдлын үнэлгээ гэсэн хэлбэрүүд багтана.

2.2. Хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан, хамтарсан багийн холбогдох гишүүд хүүхдийн эсрэг хүчирхийллийн сэжиг таамаг илэрсэн, эсхүл хүүхдийн эсрэг хүчирхийллийн талаар ирүүлсэн мэдээлэлд үндэслэн бүртгэлтэй дуудлага мэдээлэл бүрт “Гэр бүлийн эрсдэлийн нөхцөл байдлын үнэлгээ”-г энэ журмын Хавсралт 1-ийн маягтын дагуу, “Аюулгүй байдлын нөхцөл байдлын үнэлгээ”-г энэ журмын Хавсралт 2-ын маягтын дагуу тус тус хийнэ.

2.3. Гэр бүлийн эрсдэлийн нөхцөл байдлын үнэлгээг хийхдээ хүүхдийн эсрэг хүчирхийлэл ба үл хайхрах хүчирхийллийн эрсдэлүүдийг тус тусад нь үнэлж, эрсдэлийн түвшинг тогтооно. Эрсдэлийн түвшний онооны нийлбэрийг тооцоходоо хүүхдийг үл хайхрах эрсдэлүүд эсхүл хүүхдийн эсрэг хүчирхийллийн эрсдэлийн онооны нийлбэрүүдээс аль өндөр түвшинд үнэлэгдсэн эрсдэлийн түвшингөөр тооцно.

2.4. Гэр бүлийн эрсдэлийн түвшинг дараах тохиолдолд эрсдэлийн түвшинг дараагийн өндөр түвшин рүү нэмж давуулж тооцно. Үүнд:

2.6.1. Хүчирхийлэл үйлдэгч нь хүүхэдтэй хамт нэг гэрт эсхүл түүнд ойр байх магадлалтай бэлгийн хүчирхийллийн тохиолдол

2.6.2. Бага насны хүүхдийн бэртэл гэмтэл нь осол биш шалтгаантай тохиолдол

2.6.3. Ослын биш ноцтой бэртэл гэмтэл, эмнэлгийн тусламж, эмчилгээ шаардлагатай тохиолдол

2.6.4. Хүүхдийг үл хайхарсан эсхүл хүчирхийлсний улмаас хүчирхийллийн хохирогч хүүхдийн төрсөн ах эсхүл эгч эсхүл дүү нь өмнө нь эсхүл дуудлага өгөх үед нас барсан зэрэг тохиолдол багтана.

2.5. Хүчирхийлэлд өртсөн эсхүл өртөх эрсдэлтэй хүүхдийн аюулгүй байдлын нөхцөл байдлын үнэлгээний дүнд үндэслэн хүүхдийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээ, үйлчилгээний хэрэгцээг тодорхойлж, хүүхдийн аюулгүй байдлыг хангахад чиглэсэн гэрээ буюу аюулгүй байдлын төлөвлөгөөг эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, шаардлагатай тохиолдолд хүүхдийн аюулгүй байдлыг түр хамгаалах эрх бүхий байгууллага, иргэн, хүүхэд хамгааллын байгууллагын нийгмийн ажилтан, ахлах нийгмийн ажилтныг хамтран хийнэ.

2.6. Аюулгүй байдлын нөхцөл байдлын үнэлгээний дүн, аюулгүй байдлыг хангах гэрээнд төлөвлөсөн арга хэмжээ, үйлчилгээний талаар уг гэрээг байгуулахад оролцсон бүх талууд ижил ойлголттой болсон эсэхэд нийгмийн ажилтан анхаарч, энэ журмын

Хавсралт 2-ын хэсэг болох аюулгүй байдлын гэрээ, гэрээг ойлгосон тухай тодорхойлолт дээр оролцогч бүрийн гарын үсгийг зуруулна.

2.7. Аюулгүй байдлын нөхцөл байдлын үнэлгээгээр хүүхэд гэртээ байхад аюулгүй, эсхүл аюулгүй байдлыг хангах төлөвлөгөөг хэрэгжүүлэх тохиолдолд аюулгүй гэсэн дүн гарсан нөхцөлд хүүхдийн Гэр бүлийн давуу тал, хэрэгцээний нөхцөл байдлын үнэлгээ хийнэ.

2.8. Хүүхэд, түүний гэр бүлийн давуу тал, хэрэгцээний үнэлгээг энэ журмын Хавсралт 3-т батлагдсан маягтын дагуу хийж, уг үнэлгээний дүнд тулгуурлан хүүхдийг гэр бүлийн орчинд нь хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээний төлөвлөгөөг боловсруулна.

2.9. Аюулгүй байдлын нөхцөл байдлын үнэлгээнд хүүхэд гэртээ байхад аюултай гэж дүгнэлт гарсан үед Хүүхэд хамгааллын тухай хуулийн 9.2 дугаар зүйлд заасан хүүхэд асрах хувилбар үйлчилгээ үзүүлэх эрх бүхий байгууллага, гэр бүлд хүүхдийг байрлуулж, хүүхдэд гэр бүлийн орчноос нь тусдаа хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээг үзүүлнэ.

2.10. Хүүхэд хамгааллын тухай хуулийн 9.2.1 ба 9.2.2 -т заасан гэр бүлд хүүхдийг байрлуулах бол энэ журмын Хавсралт 2-т заасан Аюулгүй байдлын нөхцөл байдлын үнэлгээг давхар хийж, тэр гэр бүлд хүүхдийг байрлуулах аюулгүй гэсэн дүгнэлт гарсан тохиолдолд хүчирхийлэлд өртсөн хүүхдийг байрлуулна.

2.11. Хүүхдийн эсрэг хүчирхийлэлд өртсөн хүүхдийг гэр бүлээс нь тусдаа орчинд хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх явцад хүүхдийг гэрт нь эргэн нэгтгэх нөхцөлийг судлан, “Хүүхдийг гэр бүлд нь эргэн нэгтгэх нөхцөл байдлын үнэлгээ”-г энэ журмын Хавсралт 4-т батлагдсан маягтын дагуу хийнэ.

2.12. Хүүхдийг гэрт нь эргэн нэгтгэх нөхцөл байдлын үнэлгээгээр хүүхдийг дахин үл хайхрах, хүчирхийлэх эрсдэл бага ба дунд түвшинд үнэлэгдвэл энэ журмын Хавсралт 4-ийн Б хэсэгт батлагдсан маягтуудын дагуу хүүхдийг гэрт эргэн нэгтгэх аюулгүй байдлын нөхцөл байдлын үнэлгээг хийж, хүүхдийг гэрт нь буцаах, эргэн нэгтгэх зөвлөмжийг бичнэ.

2.13. Нөхцөл байдлын байдлын үнэлгээ нь хуульд заасан тусламж, үйлчилгээ авах хэрэгцээ, боломжийг тодорхойлох, хуулийн байгууллагад нотлох баримтын хэмжээнд үнэлэгдэх чухал ач холбогдолтой болохыг хүүхэд, түүний асран хамгаалагчид тэдэнд ойлгомжтой, тодорхой тайлбарлаж өгнө.

2.14. Нөхцөл байдлын үнэлгээг хийхдээ хүүхдийн байгаа газарт очиж, хүүхдийн нас сэтгэхүйн онцлогт тохируулан ганцаарчлан ярилцах, хүүхэд 7 нас хүрээгүй бол асран хамгаалагч, харгалзан дэмжигч, гэр бүлийн бусад гишүүдийг байлцуулан ярилцана. Хэрэв асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь хүчирхийлэл үйлдсэн болон үйлдэж болзошгүй бол гэр бүлийн бусад гишүүд, мэргэжилтэн, хөндлөнгийн хүнийг байлцуулан хийнэ.

2.15. Нөхцөл байдлын үнэлгээ хийхэд оролцох нийгмийн ажилтан, хамтарсан багийн гишүүн, бусад мэргэжилтэн нь нууцлалыг хадгалж, мэргэжлийн ёс зүйн дүрмийг баримтлана.

2.16. Хороо, сумын хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан хүүхдийн эсрэг хүчирхийллийн нөхцөл байдлын үнэлгээний бүхий л явцад харъяа дүүрэг, сумын хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан байгууллагын ахлах нийгмийн ажилтан нь мэргэжлийн удирдлагаар хангаж ажиллана.

2.17. Хороо, сумын хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан хүүхдийн эсрэг хүчирхийллийн дуудлага, мэдээллийн дагуу хийсэн нөхцөл байдлын үнэлгээ, хүүхэд хамгааллын үйлчилгээний төлөвлөгөө, явц, хяналт, үнэлгээний мэдээллийг Нийгмийн ажил, үйлчилгээний мэдээллийн нэгдсэн санд оруулна.

2.18. Хүүхдийн эсрэг хүчирхийллийн нөхцөл байдлын үнэлгээнд энэ журмын Хавсралт 1, 2, 3, 4-т батлагдсан холбогдох маягтуудыг бөглөн гарын үсэг зурж баталгаажуулсан хувь, ярилцлага, уулзалтын тэмдэглэл, эмч, шинжээчийн дүгнэлт, лабораторийн шинжилгээний хариу, гэрэл зураг, дуу, дүрс бичлэг бусад нотлох баримтыг хавсарган он, сар, өдөр, хуудас бүрд гарын үсэг зурж, сүүлийн хуудаст харьяа байгууллагын тамга дарж баталгаажуулна.

Гурав. Нөхцөл байдлын үнэлгээнд хориглох зүйл

3.1. Хүүхдийн эсрэг хүчирхийллийн нөхцөл байдлын үнэлгээ хийх үед дараах зүйлийг хориглоно:

3.1.1. нөхцөл байдлын үнэлгээ хийхдээ хүүхдийг буруутгах, тулгах, хөтлөх байдлаар асуулт тавих;

3.1.2. нөхцөл байдлын үнэлгээг хийх үед хүүхдийг хүчирхийлсэн эсхүл хүчирхийлсэн байж болзошгүй хүнтэй хамтад асуулт асуух, байлгах, уулзуулах;

Дөрөв. Бусад

4.1. Энэ журмын хэрэгжилтэд эрх бүхий байгууллага, албан тушаалтан эрхлэх асуудал, чиг үүргийн хүрээнд хяналт тавина.

--oOo--

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2024 оны сарын....-ний өдрийн/...../..... тоот хамтарсан тушаалаар баталсан журмын нэгдүгээр хавсралт

ГЭР БҮЛИЙН ЭРСДЭЛИЙН НӨХЦӨЛ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ Маягт ХХ01

Кейсийн код: Дуудлага хүлээн авсан огноо.....
Аймаг/ дүүрэг/хорооны код: Нийгмийн ажилтны нэр:
Хүүхдийн нэр:..... Үнэлгээ хийсэн огноо:
Гол асран хамгаалагчийн нэр..... Хоёр дахь асран хамгаалагчийн нэр.....

Ямар хэлбэрийн хүчирхийллийн дуудлага мэдээлэл ирснээс үл хамаарч бүх хэлбэрийн хүчирхийллийн сэжиг, таамгийн тухай мэдээлэл ирсэн тохиолдол бүрт энэхүү эрсдэлийн үнэлгээний бүх эрсдэлийг бөглөнө.

ХҮҮХДИЙГ ҮЛ ХАЙХРАХ ЭРСДЭЛҮҮД

ҮХ 1. Уг дуудлага нь хүүхэд үл хайхарсан эсхүл хүчирхийлсэн тухай дуудлага эсэх

а. Үгүй..... 0
б. Тийм 1 _____

ҮХ 2. Өмнө хийгдсэн ХХУ¹-ний нөхцөл байдлын үнэлгээний тоо

а. Огт хийгдэж байгаагүй..... 0
б. Гэр бүлийн НБҮ нэг ба түүнээс олон хийгдсэн 1
в. Эрсдэлийн нөхцөл байдлын үнэлгээ жишээ нь хүчирхийлэлд өртсөн эсэхийг тогтоох үнэлгээ нэг ба түүнээс олон хийгдсэн.....2 _____

ХҮҮХДИЙГ ЭРСДЭЛҮҮД

ХҮЧИРХИЙЛЭХ

ХХ 1. Уг дуудлага нь хүүхэд дарамталж, хүчирхийлсэн эсхүл үл хайхарсан тухай дуудлага эсэх

а. Үгүй..... 0
б. Тийм 1 _____

ХХ 2. Хүүхэд хүчирхийлэлд өртсөн эсэхийг тогтоохоор өмнө нь хийгдсэн ХХУ-ний шалган тандах нөхцөл байдлын үнэлгээний тоо

а. Огт хийж байгаагүй..... 0
б. Нэг ба түүнээс олон..... 1 _____

¹ ХХУ- Хүүхэд хамгааллын үйлчилгээ

ҮХ 3. Өмнө нь ХХҮ-г гэр бүлийн орчинд эсхүл бүлээс тусдаа орчинд авч байсан эсэх

- а. Үгүй..... 0
б. Тийм1 _____

ҮХ 4. Энэ дуудлага хийх үед тухайн гэрт амьдарч байгаа хүүхдийн тоо

- а. Хоёр эсхүл түүнээс цөөн..... 0
б. Гурав эсхүл түүнээс олон..... 1 _____

ҮХ 5. Хүүхдийн гол асран хамгаалагчийн нас
а. 30 эсхүл түүнээс настай 0
б. 29 эсхүл түүнээс залуу1 _____

ҮХ 6. Гэрт байгаа хамгийн бага хүүхдийн нас
а. 3 эсхүл түүнээс ах 0
б. 2 эсхүл түүнээс бага 1 _____

ҮХ 7. Гэрт амьдардаг насанд хүрсэн хүний тоо

- а. Хоёр эсхүл түүнээс олон..... 0
б. Нэг эсхүл байхгүй 1 _____

ҮХ 8. Асран хамгаалагчийн хүүхэд хүчирхийлсэн/үл хайхарч байсан түүх

- а. Үгүй..... 0
б. Тийм 1 _____

ХХ 3. Өмнө нь гэр бүлийн орчинд/гэр бүлээс тусдаа орчинд ХХҮ авсан түүх

- а. Үгүй..... 0
б. Нэг эсхүл түүнээс олон авсан.. 1
 Гэр бүлийн орчинд үзүүлж буй ХХҮ -ний кейс нь хаагдаагүй
 Асралт үйлчилгээний кейс нь хаагдаагүй

ХХ 4. Гэрт байгаа хамгийн бага хүүхдийн нас

- а. 4 эсхүл түүнээс бага..... 0
б. 5 эсхүл түүнээс ах 1 _____

ХХ 5. Энэ дуудлага хийх үед тухайн гэрт амьдарч байгаа хүүхдийн тоо

- а. Хоёр эсхүл түүнээс цөөн..... 0
б. Гурав эсхүл түүнээс олон..... 1 _____

ХХ 6. Асран хамгаалагчийн хүүхэд хүчирхийлсэн/үл хайхарч байсан түүх

- а. Үгүй..... 0
б. Тийм 1 _____

ХХ 7. Хүүхдийн зан авир, шинж чанар

- а. Хамаарахгүй..... 0
б. Нэг эсхүл олон1 _____
 Оюуны хөгжлийн бэрхшээлтэй
 Сэтгэцийн эрүүл мэнд ба/эсхүл зан авирын асуудалтай
 Хууль зөрчсөн түүхтэй

ХХ 8. Асран хамгаалагчийн аль нэг хэт давамгай, түрэмгий эцэг эх байх

- а. Үгүй..... 0
б. _____

ҮХ 9. Аль нэг асран хамгаалагч нь архи эсхүл мансууруулах бодис хэрэглэдэг эсхүл хэрэглэж байсан эсэх

- а. Үгүй..... 0
б. Тийм 1 _____

ҮХ 10. Аль нэг асран хамгаалагч нь сэтгэцийн эрүүл мэндийн асуудалтай эсхүл асуудалтай байсан эсэх

- а. Үгүй..... 0
б. Тийм 1 _____

ҮХ 11. Аль нэг асран хамгаалагч нь орон нутгийн үйлчилгээ, нөөц боломж авахад саад тулгардаг эсэх

- а. Үгүй..... 0
б. Нэг эсхүл хэд хэдэн удаа хандсан..... 1 _____
 Нөөц боломж хүртэх, олох хүндрэлтэй
 Боломжтой нөөц боломжийг ашиглахаас татгалзсан

ҮХ 12. Аль нэг асран хамгаалагч нь хүүхэд өсгөх ур чадвар сул

- а. Үгүй..... 0
б. Нэг эсхүл хэд хэдэн удаа хандсан..... 1 _____
 Хүүхдэдээ хараа хяналт тавьдаггүй
 Хэт их биеийн хүчний эсхүл загнаж хүмүүжүүлэх арга хэрэглэдэг
 Хүүхдийн хөгжлийн талаар мэдлэг муу

ҮХ 13. Аль нэг асран хамгаалагч нь хор хөнөөлтэй харилцаатай

- а. Үгүй..... 0
б. Тийм 1 _____

ҮХ 14. Хүүхдийн зан авир, шинж чанар

- а. Хамаарахгүй..... 0
б. Нэг эсхүл олон бэрхшээлтэй..... 1 _____

Дараагийн хуудас руу шилжих

ХХ 9. Асран хамгаалагчийн аль нэг нь гэр бүлийн хүчирхийллийн хохирогч/хүчирхийлэл үйлддэг/үйлдэж байсан

- а. Үгүй..... 0
б. Тийм 1 _____

Гол асран хамгаалагч

- Сүүлийн 12 сар дотор хохирогч байсан
 Сүүлийн 12 сараас өмнө хохирогч байсан
 Сүүлийн 12 сар дотор хүчирхийлэл үйлдсэн
 Сүүлийн 12 сараас өмнө хүчирхийлэл үйлдсэн

Хоёр дахь асран хамгаалагч

- Сүүлийн 12 сар дотор хохирогч байсан
 Сүүлийн 12 сараас өмнө хохирогч байсан
 Сүүлийн 12 сар дотор хүчирхийлэл үйлдсэн
 Сүүлийн 12 сараас өмнө хүчирхийлэл үйлдсэн

ХХ 10. Асран хамгаалагчийн одоогийн үнэлгээнд хариу өгч буй байдал

- а. Хамаарахгүй..... 0
б. Нэг эсхүл түүнээс олон 1 _____
 Асран хамгаалагч хүүхдээ өсгөх арга барилаа өөрчлөх сонирхолгүй
 Асран хамгаалагч нөхцөл байдлыг ноцтой гэж үзэхгүй байгаа
 Асран хамгаалагч хамтран ажиллаж чадахгүй

- Сэтгэцийн эрүүл мэнд ба/эсхүл зан авирын асуудалтай
- Эрүүл мэндийн хувьд асуудалтай эсхүл оношилж чаддаггүй
- Оюуны хөгжлийн бэрхшээлтэй
- Суралцахуйн бэрхшээлтэй
- Биеийн хөгжлийн бэрхшээлтэй

ҮХ 15. Орон гэр/үндсэн хэрэгцээ хангагдаагүй

- а. Хамаарахгүй..... 0
- б. Нэг эсхүл олон бэрхшээлтэй..... 1
- Хоол хүнс ба эсхүл хувцас муутай _____
- Орон гэргүй эсхүл аюулгүй биш

ХХ 11. Аль нэг асран хамгаалагч нь бусадтай харилцахдаа асуудалтай.

- а. Үгүй 0
- б. Нэг эсхүл олон 1 _____
- Бусадтай харилцахдаа учир дутагдалтай
- Харилцаа муутай

ҮЛ ХАЙХРАХ ЭРСДЭЛИЙН НИЙТ ОНОО _____

ХҮЧИРХИЙЛЭЛД ЭРСДЭЛИЙН НИЙТ ОНОО _____

ӨРТӨХ _____

ЭРСДЭЛИЙН

ТҮВШНИЙ

ҮНЭЛГЭЭ

Дараах түвшний аль өндрөөр нь гэр бүлийн эрсдэлийн түвшинг тооцно.

- | | | |
|---------------------------|--------------------------------------|--------------------------------|
| Үл хайхрах эрсдэлийн оноо | Дарамт, хүчирхийллийн эрсдэлийн оноо | Эрсдэлийн түвшин |
| • -1-2 | • -1-2 | <input type="checkbox"/> Бага |
| • 3-5 | • 3-5 | <input type="checkbox"/> Дунд |
| • 6-16 | • 6-16 | <input type="checkbox"/> Өндөр |

ЭРСДЭЛИЙН ТҮВШИНГ ДАВУУЛЖ НЭМЭХ

Өндөр түвшин рүү нь шилжүүлж, тохирох нөхцөлийг тэмдэглэх

- Хүчирхийлэл үйлдэгч нь хүүхэдтэй ойр байх магадлалтай бэлгийн хүчирхийллийн тохиолдол
- Бага насны хүүхдийн бэртэл гэмтэл нь осол гэмтлийн биш байх тохиолдол
- Осол гэмтлийн биш ноцтой бэртэл гэмтэл, эмнэлгийн тусламж, эмчилгээ шаардлагатай
- Үл хайхрах ба хүчирхийллийн улмаас төрсөн ах, эгч, дүү нь өмнө эсхүл сая нас барсан

Өөрчилж давуулсан шалтгаан (Ахлах буюу мэргэжлийн удирдагчийн зөвшөөрлөөр нэг түвшин дээшлүүлэх ба бууруулна): Шалтгааныг дараах зайд тайлбарлан бичих

Шалтгаан: _____

ДАВУУЛЖ НЭМСНИЙ ДАРААХ ЭРСДЭЛИЙН ТҮВШИН

Бага Дунд Өндөр

Нийгмийн ажилтан: _____ . Огноо: _____

Шалгасан/Түвшин нэмэхийг баталсан

Ахлах нийгмийн ажилтан: _____ Огноо: _____

ТӨСӨӨЛ

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2023 оны сарын....-ний өдрийн/...../..... тоот хамтарсан тушаалаар баталсан журмын хоёрдугаар хавсралт

АЮУЛГҮЙ БАЙДЛЫН НӨХЦӨЛ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ
Маягт ХХ02

Кейсийн дугаар: Дуудлага хүлээн авсан огноо.....
Аймаг/ дүүрэг/хорооны код: Нийгмийн ажилтны нэр:
Хүүхдийн нэр:..... Үнэлгээ хийсэн огноо:
Гол асран хамгаалагчдын нэр.....

ХЭСЭГ А. ХҮҮХДИЙН ЭМЗЭГ БАЙДАЛД НӨЛӨӨЛӨХ ХҮЧИН ЗҮЙЛС

Эдгээр хүчин зүйлд нь хүүхдийн өөрийгөө хамгаалах чадваргүйд хүргэх нөхцөлүүд хамаарна. Ямар ч хүүхдэд хамаарах бүх хүчин зүйлийг тэмдэглэ.

<input type="checkbox"/> Хүүхэд 0-5 настай.	<input type="checkbox"/> Хүүхдийн сэтгэн бодох чадвар сул.
<input type="checkbox"/> Хүүхэд эрүүл мэндийн болон сэтгэцийн эрүүл мэндийн хувьд ямар нэг асуудалтай гэж таамаглагдсан эсхүл оношлогдсон.	<input type="checkbox"/> Хүүхдийн бие бялдрын хөгжил муу.
<input type="checkbox"/> Хүүхдийг хамгаалах сүлжээ хязгаарлагдмал эсхүл шууд дэмжлэг авах боломжгүй	<input type="checkbox"/> Аль нь ч хамаарахгүй

ХЭСЭГ Б. ОДОО ТУЛГАРЧ БУЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Хүүхдэд аюул занал учруулах, хор хөнөөлтэй зан үйл, нөхцөлийг тодорхойлох аюулгүй байдлын үзүүлэлтүүд энэ хэсэгт хамаарна. Үзүүлэлт тус бүрийг үнэлнэ. Үнэлгээ хийх үед тухайн гэр бүлд дараах үзүүлэлтүүд илэрч байвал ТИИМ, харин аль нэг эсхүл бүх үзүүлэлтүүд илрэхгүй байвал ҮГҮЙ гэдэг хариултыг дугуйлна.

1.	Тийм Үгүй	Асран хамгаалагч нь хүүхдийн бие махбодыг ноцтой гэмтээсэн эсхүл хэн нэгэн хүүхдийг ноцтой гэмтээх боломж олгосон эсхүл худлаа айлган сүрдүүлэх зэрэг замаар дараах нөхцөл байдал үүссэн бол
		• Ослын биш шалтгаантай гэмтэл бэртэл, хүчирхийлэл
		• Асран хамгаалагчийн хүүхэдтэй зүй бус харьцах харьцаа
		• Хүүхдийн эсрэг хүчирхийлэл, хор хөнөөл учруулахуйц сүрдүүлэлт
		• Шалтгаангүй эсхүл хүчирхийлэлд тооцохуйц хүч хэрэглэх
		• Нярай/хүүхдийн биед/цусанд архи, мансууруулах бодис илэрсэн
		• Асран хамгаалагч нь хүүхдийн биеийг гэмтээх эсхүл үйл ажиллагааг алдагдуулах хүчтэй эрсдэлтэй үйлдэл
		• Асран хамгаалагч нь хүүхдийг гэмтээх гэж оролдсон ба буруу зүйл хийсэндээ үл гэмшсэн байдал
		• Хүүхэд нас барсан

			Тайлбар:
2.	Тийм Үгүй	Хүүхэд дараах хүмүүсийн аль нэгний бэлгийн хүчирхийлэл өртсөн байж болзошгүй сэжиг таамаг:	
		•	Эцэг эх
		•	Бусад асран хамгаалагч, эсхүл
		•	Танихгүй хүн, БА хязгаарлах дүрэмгүй эцэг эх эсхүл асран хамгаалагч, БА хүүхдийн аюулгүй байдлыг шууд алдагдуулах нөхцөл
			Тайлбар:
3.	Тийм Үгүй	Асран хамгаалагч нь аюул учруулахыг мэддэг БА туслах хүсэлгүй ЭСХҮЛ бусдын айлган сүрдүүлэлт эсхүл ноцтой хор уршгаас хүүхдийг хамгаалах чадваргүй. Үүнд бие махбодын хүчирхийлэл, сэтгэл санааны хүчирхийлэл, дарамт, бэлгийн хүчирхийлэл, эсхүл үл хайхрах явдал хамаарна. (Гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой зан үйл нь энэ үнэлгээний 10-р үзүүлэлтэд хамаарна).	
		•	Ноцтой аюул занал эсхүл хүүхэдтэй ойр байдаг, эсхүл хүүхдэд ойртох боломжтой өрх, гэр бүлийн бусад гишүүдийн айлган сүрдүүлэлтээс асран хамгаалагч нь хүүхдийг хамгаалж чадахгүй
		•	Саяхан, өмнө нь хүчирхийлэл үйлдэж байсан эсхүл ноцтой хүчирхийлэгч зан үйлтэй хэн нэгэн хүүхдийн гэрт амьдардаг эсхүл түүнд хүүхдийн асран хамгаалагч хүүхэдтэй байнга ойр байх боломж олгодог
			Тайлбар:
4.	Тийм Үгүй	Хүүхдийн гэмтлийн талаарх асран хамгаалагчийн тайлбар нь учир дутагдалтай, эсхүл гэмтсэн гэмтлийн шинжтэй нь тайлбар тохирохгүй, гэмтлийн үүсэл, шинж чанар нь хүүхдийн аюулгүй байдалд шууд санаа зовох хэрэгтэй харуулсан.	
		•	Эмнэлгийн шинжилгээ, үзлэгээр гэмтэл бэртэл хүчирхийллийн үр дагавар болохыг харуулсан; асран хамгаалагч осол гэмтлийн талаар тайлбар өгөхгүй байх, тайлбарлахаас зайлсхийсэн
		•	Гэмтэл бэртлийн талаарх асран хамгаалагчийн тайлбар нь шарх, бэртлийн хэлбэртэй тохирохгүй
		•	Асран хамгаалагч нь хүүхдийн гэмтэл, бэртлийн шалтгааныг хүүхдэд аюул, хор уршиг бага нөлөөлөх байдлаар тайлбарласан.
		•	Асран хамгаалагч болон бусад хүүхэд харсан, хүүхэдтэй харилцсан хүмүүсийн тайлбарууд нь маш их зөрүүтэй эсхүл бие биеэ үгүйсгэсэн.
			Тайлбар:
5.	Тийм Үгүй	Ноцтой аюул, хөнөөлөөс хүүхдийг хамгаалах талаар асран хамгаалагч нь анхаарч, хянаж чаддаггүй.	
		•	Асран хамгаалагч нь байдаг ч хүүхэд нь гадуур ганцаараа явж, аюултай зүйлээр тоглох, эсхүл цонхны ирмэг дээгүүр явдаг гэх мэт.
		•	Асран хамгаалагч нь хүүхдээ ганцааранг нь орхидог (хүүхдийн нас, хөгжлийн байдлаас хамаарч үлдээсэн хугацааг өөрөөр тооцно).

		<ul style="list-style-type: none"> Хүүхэд харах, асруулах төлөвлөгөө маш муу хийдэг эсхүл хүүхдэдээ тохирсон зохицуулалт хийж чаддаггүй. 	
		<ul style="list-style-type: none"> Асран хамгаалагчийн байгаа газар нь мэдэгдэхгүй, тодорхой биш. 	
		Тайлбар:	
6.	Тийм Үгүй	Асран хамгаалагч нь хүүхдээ хооллох, эсхүл хувцаслах наад захын хэрэгцээг хангадаггүй.	
		<ul style="list-style-type: none"> Хүүхэд идэх хоолгүй, хоол авах боломжгүй, эсхүл хүүхэд удаан хугацаанд өлсөж, цангаж хоол ундгүй байсан. 	
		<ul style="list-style-type: none"> Хүүхэд тураалтай харагдаж байгаа. 	
		<ul style="list-style-type: none"> Хүйтний улиралд хүүхэд наад захын дулаан хувцасгүй. 	
		Тайлбар:	
7.	Тийм Үгүй	Хүүхдийн эрүүл мэндийн эсхүл сэтгэцийн эрүүл мэндийн (амиа хорлох, амиа хорлоход хүргэх) хүнд үед яаралтай тусламж авах хэрэгцээг асран хамгаалагч нь хангадаггүй	
		<ul style="list-style-type: none"> Асран хамгаалагч нь хүүхдийн эрүүл мэндийн нэн шаардлагатай эмчилгээг эрэлхийлдэггүй, эсхүл эмчийн бичиж өгсөн эмчилгээг дагаж хийдэггүй. 	
		<ul style="list-style-type: none"> Хүүхэд тусгай/онцгой хэрэгцээтэй, эцэг эх нт тэр хэрэгцээг нь хангадаггүй. 	
		<ul style="list-style-type: none"> Хүүхэд амиа хорлохыг оролдсон, эцэг эх нь хамгаалах арга хэмжээ аваагүй. 	
		<ul style="list-style-type: none"> Хүүхэдтэй зүй бус харьцсан шинж тэмдэг хүүхдэд илэрсэн (сэтгэл санааны хам шинжүүд, зан үйлээ хянах чадвар сул, бие махбодын хам шинжүүд гэх мэт) 	
		Тайлбар:	
8.	Тийм Үгүй	Амьдарч буй орчин нь хортой, хүүхдийн эрүүл мэнд ба/эсхүл аюулгүй байдалд шууд аюул занал учруулахуйц нөхцөлтэй.	
		<ul style="list-style-type: none"> Зуух эсхүл халаалтын хэсгээс газ алдаж байгаа 	
		<ul style="list-style-type: none"> Шүүгээний доод цоожгүй шургуулгад эсхүл доор хүүхэд хүрэх газарт аюултай бодис эсхүл зүйлс хадгалсан. 	
		<ul style="list-style-type: none"> Ус, халаалт, цахилгаан дутагдалтай, хангамж муу (зуухыг халаалтын эх үүсвэр байдлаар ашигладаг гэх мэт) 	
		<ul style="list-style-type: none"> Нээлттэй/ өвдөрхий цонхтой эсхүл цонхгүй 	
		<ul style="list-style-type: none"> Цахилгааны ил утастай 	
		<ul style="list-style-type: none"> Эрүүл мэндэд хортой их хэмжээний хог, хоолны хаягдал их хадгалагдсан 	
		<ul style="list-style-type: none"> Одоогийн амьдарч буй нөхцөлөөс үүдэлтэй хүнд өвчлөл, их гэмтэл бэртэл авах (хар тугалганы хордлого, харахад хазуулах гэх) 	
		<ul style="list-style-type: none"> Амьдарч буй байр, орчинд нь хүн эсхүл малын ялгадастай 	
		<ul style="list-style-type: none"> Буу болон галт зэвсгээ цоожтой, эсхүл хүүхэд авах боломжгүй газар хадгалаагүй. 	
		<ul style="list-style-type: none"> Хүүхдийн байдаг газар/орчинд аюултай мансууруулах бодис үйлдвэрлэдэг. 	
		Тайлбар:	
9.	Тийм Үгүй	Асран хамгаалагчийн мансууруулах бодисын хэрэглээ нь түүний хүүхдээ асрах, хамгаалах, хянах чадварт ноцтой нөлөөлдөг.	

		<ul style="list-style-type: none"> Асран хамгаалагч нь мансууруулах бодис эсхүл архи согтууруулах ундаа их хэмжээгээр хэрэглэж байна. 	
		<ul style="list-style-type: none"> Одоогийн, байнгын мансууруулах бодисын хэрэглээ нь хүүхдийг шууд үл хайхрах ба/эсхүл хүчирхийлэх хэмжээнд хүргэхээр нөхцөл байдалтай байна. 	
		Тайлбар:	
10.	Тийм Үгүй	Гэрт нь эсхүл амьдарч буй айлд нь гэр бүлийн хүчирхийлэл болдог, энэ нь хүүхдийн бие махбод ба сэтгэл санаанд ноцтой хор хөнөөл учруулдаг.	
		<ul style="list-style-type: none"> Хүүхдийн гэрт, хүүхдэд хамгийн ойр насанд хүрэгчдийн хооронд болох гэр бүлийн хүчирхийлэл, хүчирхийлэлтэй зан үйл нь хүүхэд бие махбодын хүчирхийлэлд өртөхөд хүргэх их аюултай. Мөн гэрт болж буй гэр бүлийн хүчирхийллийг хамгийн ойроос харах, сонсох болно. 	
		Тайлбар:	
11.	Тийм Үгүй	Асран хамгаалагч нь хүүхдийг муу, муухайгаар байнга хэлэх, эсхүл хүүхдийн эсрэг сөрөг үйлдэл хийх, энэ сөрөг харьцаа, үйлдэл нь хүүхэд өөрийгөө эсхүл бусдыг аюулд оруулах үйлдэл хийх, амиа хорлох, хэрцгий харьцах эсхүл зугтах зайлах зэрэг үйлдэл хийхэд хүргэнэ.	
		<ul style="list-style-type: none"> Асран хамгаалагч нь хүүхдийг үгүйсгэх, (тэнэг, мангар, муухай, чөтгөр гэх мэт) доош хийх байдлаар хүүхдийг хэд хэдэн удаа тодорхойлдог. 	
		<ul style="list-style-type: none"> Асран хамгаалагч нь дахин дахин хүүхдийг доош хийх, харааж зүхдэг. 	
		<ul style="list-style-type: none"> Тухайн хүүхдийг гэрт нь асран хамгаалагч байнга буруутгадаг. 	
		<ul style="list-style-type: none"> Хүүхдийн тодорхой нэг болсон үйл явдалд буруутгах эсхүл хүүхдийг гаргасан зан авирыг хүүхэд хүчирхийлэх шалтгаан болсон гэж үздэг. 	
		<ul style="list-style-type: none"> Хүүхдийн нас, хөгжлийн түвшнээс ахадсан зүйл, зан үйлийг хүүхдээс хүсдэг. 	
		<ul style="list-style-type: none"> Асран хамгаалагчийн эсхүл гэр бүлийн асуудалд хүүхэд хариуцлага хүлээнэ гэж асран хамгаалагч нь үзэх 	
		Тайлбар:	
12.	Тийм Үгүй	Асран хамгаалагчийн биеийн махбод, сэтгэл санааны тогтворгүй байдал, хөгжлийн түвшин эсхүл танин мэдэхүйн хөгжлийн хоцрогдол зэрэг нь хүүхдийг асрах, хамгаалах, харж хянах одоогийн чадварыг алдагдуулж байна.	
		<ul style="list-style-type: none"> Асран хамгаалагчийн бие махбодын нөхцөл байдал нь хүүхэд асрах, өсгөх чадварыг ноцтой алдагдуулдаг. 	
		<ul style="list-style-type: none"> Асран хамгаалагчийн сэтгэл санааны тогтворгүй байдал, орилж хашхирах, буруу ташаа төсөөлөл зэрэг хүүхэд өсгөх чадварыг алдагдуулдаг. 	
		<ul style="list-style-type: none"> Асран хамгаалагчийн сэтгэл гутрал эсхүл итгэл найдвараа алдах, тусламж авах боломжгүй мэт санагдах зэрэг нь хүүхэд болон гэр бүлээ хэвийн авч явах сэдлийг бууруулна. 	
		<ul style="list-style-type: none"> Хүүхдийн сэтгэл хөдлөл, бие махбод, эсхүл сэтгэцийн хэвийн үйл ажиллагааны алдагдалтай холбоотой зан авир нь асран хамгаалагчид их хэцүү хүнд санагддаг. 	
		<ul style="list-style-type: none"> Асран хамгаалагчийн танин мэдэхүйн хөгжлийн хоцрогдлоос үүдэлтэй хүүхэд асарч өсгөх чадвар нь сул. 	
		Тайлбар:	

13.	Тийм	Үгүй	Хүүхдийн гэр бүлийнхэн нөхцөл байдлын үнэлгээ хийлгэхээс зайлсхийж хүүхдийг нуух, хүүхэдтэй харьцах боломж олгохгүй байна.
			• Хүүхдийн гэр бүлийнхэн хүүхдийн байрлаж буй газрыг зааж өгөхгүй, хүүхэдтэй харилцах боломж олгохоос татгалзсан.
			• Хүүхдийн гэр бүлийнхэн эмнэлгийн тусламж, зөвлөгөө авахаас зайлсхийж хүүхдийг эмнэлгээс гаргасан.
			• Хүүхэд хамгааллын байгууллагын өмнөх нөхцөл байдлын үнэлгээний дагуу заасан арга хэмжээг аваагүй.
			• Хүүхэд хамгааллын байгууллагын нөхцөл байдлын үнэлгээнээс удаан хугацаанд зайлсхийж, хүүхдийг сургууль руу нь явуулахгүй, найз нөхөдтэй нь уулзуулахгүй, гадагшаа гаргахгүй байсан түүхтэй.
			• Хүүхдийн гэр бүлийнхэн хүүхэд хамгааллын байгууллагын нөхцөл байдлын үнэлгээнээс зайлсхийх, саад болохыг оролдсон.
			Тайлбар:
14.	Тийм	Үгүй	Одоогийн нөхцөл байдал, мөн өөрийн асрамжид байсан хүүхэдтэй зүй бус харьцаж байсан гэсэн өмнөх мэдээлэлтэй хавсарсан, улмаар өмнө нь хүүхэдтэй зүй бус харьцаж байсан эсхүл өмнөх хүүхдийн эсрэг хүчирхийллийн тохиолдолд асран хамгаалагчийн хандах хандлага зэрэг нь хүүхдийн аюулгүй байдалд нэн даруй санаа зовоход хүргэж байна.
			• Өмнөх хүүхдийн үхэл
			• Хүүхдийг өмнө нь ноцтой гэмтээж байсан.
			• Эцэг эх байх эрхийг нь цуцалсан.
			• Хүүхдийг өмнө нь түр хамгаалах байранд байрлуулж байсан.
			• Хүүхэд хүчирхийлэлд өртсөн эсхүл үйлчилгээ шаардлагатай гэж хүүхэд хамгааллын байгууллагаас өмнө нь тогтоож байсан.
			• Өмнө нь хүүхэд хор хөнөөл учруулна гэж айлган сүрдүүлж байсан.
			• Асран хамгаалагч өмнө нь мэргэжлийн туслалцааг тасалж, зогсоож байсан.
			Тайлбар:
